ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

| | | |
|---|---|---|
| 2008 оны 10 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 680 | Улаанбаатар хот |

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 79.7, Улсын гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Барааг хүлээн авахаас татгалзах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 1 дүгээр,
“Бараа устгах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 2 дугаар,
“Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг гаалийн хилээр нэвтрүүлэх гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тушаалын биелэлтийг зохион байгуулж, харъяа гаалийн газар, хороодыг удирдамж чиглэлээр хангаж ажиллахыг Хяналт, эрсдлийн удирдлагын газар /Д. Оюунчимэг/-т үүрэг болгосугай.

3. Шинэчлэн батлагдсан гаалийн бүрдүүлэлтийн горимын кодыг ГАМАС-ийн ангилалтын санд 2008 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор оруулахыг Мэдээллийн технологийн төв /Б.Цог/-д даалгасугай.

4. Энэ тушаалыг 2009 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА Д. ЦЭВЭЭНЖАВ

**Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2009 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 2985 дугаарт бүртгэлтэй.**

Улсын гаалийн ерөнхий газрын
даргын 2008 оны 680 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

# БАРААГ ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗАХ ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Бараанг хүлээн авахаас татгалзах гаалийн бүрдүүлэлтийн горим /Гаалийн тухай хуулийн 202-207 дугаар зүйл, цаашид “горим” гэх/-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.

1.2. Хүлээн авагч нь хүлээн авахаас татгалзсан барааг горимд байршуулах, төрийн өмчлөлд шилжүүлж горимыг дуусгавар болгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Мэдүүлэгч Гаалийн тухай хуулийн 202.2-т зааснаар горимд байршуулах барааны тээвэрлэлт, зуучлал, хадгалалттай холбогдон гарах зардлыг хариуцна.

## Хоёр. Горимын код

2.1. Горимд байршуулах бараанд эрх бүхий байгууллагаас тогтоосон тоо хэмжээний болон бусад хязгаарлалт хамаарахгүй.

2.2. Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

| | Горимын утга | Горимын код |
|---|---|---|
| 1 | Барааг хүлээн авахаас татгалзах горим | 980 |

## Гурав. Бичиг баримт

3.1 Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийхэд дараах бичиг баримтыг шаардана.

3.1.1. барааг хүлээн авахаас татгалзсан тухай хүлээн авагч бичгээр гаргасан хүсэлт;

3.1.2. горимд байршуулах бараа нь эрүүл ахуй, чанарын шаардлага хангаж байгаа талаар гаргасан холбогдох байгууллагын дүгнэлт;

3.1.3. үнийн нэхэмжлэх, баглаа боодлын жагсаалт, техникийн бичиг баримт зэрэг худалдааны бичиг баримт/;

3.1.4. тээврийн бичиг баримт;

3.1.5. шаардлагатай бусад бичиг баримт.

3.2. Энэ журмын 3.1-д заасан мэдээлэл, бичиг баримт нь горимын шаардлага хангахгүй байвал гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.

3.3. Энэ горимын дагуу байршуулах барааны гаалийн мэдүүлэгт гаалийн улсын байцаагч “Монголын гааль зөвшөөрөв” хяналтын тэмдэг дарна.

## Дөрөв. Горимын шаардлага

4.1. Горимд Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг байршуулахгүй.

4.2. Горимд байршуулах бараа нь Гаалийн тухай хуулийн 203.1-д заасан шаардлагыг хангасан байна.

4.2. Горимд байршуулах бараанд Гаалийн тухай хуулийн 204 дүгээр зүйлд зааснаар гаалийн болон бусад татвар ногдуулахгүй.

4.3. Мэдүүлэгч нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг  хуульд заасан хугацаанд гаргаж өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй бол гаалийн байгууллага мэдүүлэгчийн сонгосон горимд барааг байршуулахаас татгалзана.

**Тав. Бусад**

5.1. Хүлээн авахаас татгалзах горимд байршуулсан барааг төрийн өмчлөлд шилжүүлснээр энэ горим дуусгавар болно.

5.2. Горимд  байршуулсан бараанд “Барааг улсын орлогод шилжүүлэх хуудас” бичиж төрийн өмчлөлд шилжүүлнэ.

5.3. Гаалийн тухай хуулийн 298.2 нь энэ журмын 5.2-т заасны дагуу төрийн өмчлөлд шилжүүлсэн  бараанд хамаарахгүй болно.

Улсын гаалийн ерөнхий газрын
даргын 2008 оны 680 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

# БАРАА УСТГАХ ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Бараа устгах гаалийн бүрдүүлэлтийн горим /Гаалийн тухай хуулийн 208-214 дүгээр зүйл, цаашид "горим" гэх/-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.

1.2. Гаалийн хяналтад байх хугацаанд гэмтэж муудсан, чанарын шаардлага хангахгүй болсон, мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлтээр эрүүл ахуй, эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй гэж тогтоогдсон, 3 хоногоос дээш хугацаанд буцаан гаргаагүй улсын хилээр оруулахыг хориглосон бараа болон Гаалийн тухай хуулийн 203.2-т зааснаар борлуулсны дараа зардлаа нөхөн боломжгүй барааг  гаалийн хяналтын дор устгах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Мэдүүлэгч нь барааг устгах горимд байршуулах хүсэлтээ гаалийн байгууллагад бичгээр гарган өгсөн байх бөгөөд горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг уг горимд байршуулна.

1.4. Энэ горимд байршуулсан барааг байгаль орчинд хор хөнөөлгүй аргаар анхны зориулалтаар ашиглах боломжгүй болгон гаалийн хяналтан дор устгана.

1.5.  Бараа устгах горимыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан аливаа зардлыг бараа эзэмшигч хариуцна.

1.6. Бараанд устгал хийхдээ хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд ямар нэг хор хохирол учруулахгүй, аль нэг байгууллага хувь хүний ашиг сонирхлын дагуу хийгдээгүй байх зарчмыг баримтлана.

## Хоёр.Горимд байршуулах бараа, горимын код

2.1.  Горимд дараах барааг байршуулна:

2.1.1.гаалийн хяналтад байх хугацаанд гэмтэж муудсан, чанарын шаардлага хангахгүй болсон, эрүүл ахуйн, эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй болох нь мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон гадаадын бараа;

2.1.2. гаалийн хяналтын бүс, түр агуулахаас 3 хоногийн дотор хилийн чанадад буцаан гаргаагүй  улсын хилээр оруулахыг хориглосон гадаадын бараа.

2.2. Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

| | Горимын утга | Бүрдүүлэлт хийх горимын код |
|---|---|---|
| 1 | Бараа устгах | 990 |

2.3. Горимд Гаалийн тухай хуулийн 209.1-д заасан барааг байршуулахгүй

## Гурав. Бичиг баримт

3.1. Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийхэд Гаалийн тухай хуулийн 213,1-д заасан бичиг баримтыг шаардана.

3.2. Байгаль орчин, хүний амь нас, эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэх элдэв төрлийн химийн болон цацраг идэвхит бодис устгах бол холбогдох мэргэжлийн байгууллага, албан тушаалтнаас тусгайлан зөвшөөрөл авна.

3.3. Энэ горимын дагуу байршуулах барааны гаалийн мэдүүлэгт гаалийн улсын байцаагч “Монголын гааль зөвшөөрөв” хяналтын тэмдэг дарна.

## Дөрөв. Горимын шаардлага

4.1. Гаалийн тухай хуулийн 212,1-д зааснаас гадна барааг устгахад гаалийн байгууллага хяналт тавих боломжгүй тохиолдолд барааг устгаж үл болно.

4.2. Бараа устгах комисс нь мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлт, бараа устгахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хууль болон түүнтэй холбогдсон эрх зүйн актуудын шаардлагын дагуу ажиллаж устгал хийнэ.

4.3. Барааг дараах байдлаар устгана:

4.3.1. халаах, шатаах, хими, механикийн аль боломжтой аргаар бүрэн устгах;

4.3.2. анхны зориулалтаар ашиглах болон сэргээн босгох боломжгүй болгон задалж салгах, ялгаж ангилах, механик эвдрэлд оруулах.

4.4. Барааны устгалын үр дүнд уг бараа нь хэрэглээний анхны шинж байдал, худалдан борлуулах өртгөө бүрэн алдсан байна.

4.5. Гаалийн тухай хуулийн 210 дугаар зүйлд зааснаар энэ горимд байршуулах бараанд гаалийн болон бусад татвар ногдуулахгүй.

4.6. Устгасан барааны анхны зориулалт өөрчлөгдсөн ч цаашид өөр зориулалтаар ашиглах боломжтой нь гаалийн лабораторийн дүгнэлт, мэргэжлийн хяналтын албадын шинжилгээ, судалгаагаар тогтоогдвол гаалийн удирдах төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн дараагийн хэрэглэгчдэд шилжүүлэх бөгөөд түүнийг устгалын горимоос гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд шилжүүлнэ.

4.7. Барааг устгах явцад бий болсон цаашид өөр зориулалтаар ашиглах боломжтой хаягдал хэсэг, үлдэгдлийг импорт, экспортын барааны нэгэн адилаар гаалийн хяналтан дор хадгалж, гаалийн мэдүүлэг бичнэ.

## Тав. Бусад

5.1. Гаалийн байгууллагаас томилсон устгалын комисс нь устгалын үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

5.2. Барааг устгах комисс нь уг бараа эзэмшигчийг байлцуулан устгалыг зохих заавар, шаардлагын дагуу хийж, энэ журмын хавсралтаар баталсан маягтын дагуу бараа устгасан тухай актыг 3 хувь үйлдэж, гарын үсэг зурж баталгаажуулан, эх хувийг гаалийн байгууллагад, 2 дугаар хувийг устгал хийх тухай дүгнэлт гаргасан байгууллагад, 3 дугаар хувийг бараа эзэмшигчид, эсхүл зуучлагчид тус тус олгоно.

ГЕГ-ын даргын 2008 оны 680 тушаалын
2 дугаар хавсралтаар батлагдсан
журмын хавсралт

______________________________
(гаалийн газар, хорооны нэр)

БАРАА УСТГАСАН ТУХАЙ АКТ

_____оны ___ дугаар сарын ____-ны өдөр __________________аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс гаалийн __________ дугаартай мэдүүлгээр улсын хилээр оруулсан _________нэр төрлийн ___________________________
______________________________________________________
(барааны нэр, тоо хэмжээ)
бараа нь хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд _________________________болох нь ____________________________
(мэргэжлийн хяналтын байгууллагын нэр)
дүгнэлтээр тогтоогдсон тул __________________________ -т ______________ аргаар устгав.
Устгалтын үр дүнд ________________________________________
(хаягдал, үлдэгдлийн нэр, тоо хэмжээ)
үүсч бий болсон болохыг тодорхойлов.
Үлдэгдлийг __________________________________________ газарт хадгалав.

Бараа устгах комисс: __________________( )
____________________( )
____________________( )
____________________( )
____________________ ( )

(устгалтад оролцсон хүмүүсийн нэр, албан тушаал гарын үсэг)

Барааг эзэмшигч,
Эсхүл зуучлагч ________________________________
(нэр, албан тушаал, гарын үсэг)

Устгал хийсэн ажилчид ________________________________
( нэр, иргэний үнэмлэх, регистрийн дугаар,гарын үсэг)

________________________________ ____________
( нэр, иргэний үнэмлэх, регистрийн дугаар,гарын үсэг)

Улсын гаалийн ерөнхий газрын
даргын 2008 оны 680 дугаар
тушаалын 3 дугаар хавсралт

# УЛС ХООРОНДЫН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРААГ НЭВТРҮҮЛЭХ ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улс хоорондын тээврийн үйлчилгээнийн барааг нэвтрүүлэх гаалийн бүрдүүлэлтийн горим /Гаалийн тухай хуулийн 215-219 дүгээр зүйл/-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн тухай хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.

1.2. Энэ журмаар улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг нэвтрүүлэх гаалийн бүрдүүлэлтийн горимтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.3. Горимыг мэдүүлэгч өөрөө сонгох бөгөөд горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг уг горимд байршуулна.

## Хоёр. Горим байршуулах бараа, горимын код

2.1 Горимд гаалийн тухай хуулийн 216.1-д заасан барааг байршуулна.

2.2. Улс хоорондын тээврийн үйлчилгээ эрхэлж буй дотоодын тээврийн хэрэгсэлд нийлүүлэх шатах, тослох материалыг энэ горимд байршуулахыг хориглоно.

2.3. Улс хоорондын тээврийн үйлчилгээний бараа нь хориглосноос бусад хязгаарлалтад хамаарахгүй.

2.4. Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

| | Горимын утга | Бүрдүүлэлт хийх горимын код | Өмнөх мэдүүлгийн горимын код |
|---|---|---|---|
| 1 | Барааг гаалийн баталгаат агуулахаас улс хоорондын тээврийн үйлчилгээнд гаргах | 910 | 700-708 |
| 2 | Монголын барааг улс хоорондын тээврийн үйлчилгээнд гаргах | 911 | шаардахгүй |

2.5. Гаалийн бүрдүүлэлтийн горимын 911 кодоор бүрдүүлэлт хийхэд гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа улс хоорондын тээврийн үйлчилгээнд шаардагдах хүнсний зүйлс хамаарна.

## Гурав. Бичиг баримт

3.1. Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийхэд дараах бичиг баримтыг шаардана.

3.1.1. худалдааны бичиг баримт /зорчигчдын бараа материалын хангалтын падаан/;

3.1.2. гадаад худалдааны гэрээ;

3.1.3. барааны тохиролын гэрчилгээ;

3.1.4. эрүүл ахуйн шаардлагыг хангасан тухай холбогдох байгууллагын дүгнэлт.

3.2. Мэдүүлэгч 3.1-д заасан бичиг баримтыг электрон шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.

3.3. Журмын 3.1-д заасан мэдээлэл, баримт бичиг нь горимын шаардлага хангахгүй байвал гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.

3.4. Энэ горимын дагуу байршуулах барааны гаалийн мэдүүлэгт гаалийн улсын байцаагч “Гаалийн хяналтад байгаа” хяналтын тэмдэг дарна.

## Дөрөв. Горимын шаардлага

4.1. Олон улсын аялалын хугацаа, аялалын үйлчилгээнд зарцуулах бараа, материалын норм хэмжээг тухайн аялалыг зохион байгуулж буй байгууллага гаалийн байгууллагад урьдчилан гаргаж өгсөн байна.

4.2. Олон улсын аялалын үйлчилгээнд хэрэглэх бараа, материал нь гаалийн зорилгоор тэмдэглээ хийх боломжтой баглаа боодолтой /сав, чингэлэгт хийгдсэн/ байна.

4.3. Барааг улс хоорондын тээврийн үйлчилгээний горимд байршуулахад гаалийн болон бусад татвар ногдуулахгүй.

4.4. Дотоодын хэрэглээнд зориулан оруулсан барааг энэ горимд байршуулахад импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.

4.5. Мэдүүлэгч нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг хуульд заасан хугацаанд гаргаж өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй бол гаалийн байгууллага мэдүүлэгчийн сонгосон горимд барааг байршуулахаас татгалзана.

## Тав. Бусад

5.1. Улс хоорондын тээврийн аялал үйлчилгээний барааг нэвтрүүлэх горим барааг зориулалтаар нь зарцуулснаар дуусгавар болно.